



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/290

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөрөнгийн хуваарь батлах тухай” 2020 оны А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс Баянмөнх сумын Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Баянмөнх сумын Засаг дарга /М.Цэнгэл/-д үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус дааласугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
..06.. дугаар сарын 17 өдрийн А/090
дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
1.	Ахмадын байгууллагын тоног төхөөрөмж /Хэнтий, Баянмөнх сум/	2020	2020	5.0	5.0	Баянмөнх сумын Засаг дарга
	Нийт дүн			5.0	5.0	